

БАТЛАВ.

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА

М.БАДАМСҮРЭН

“САЙН ДУРЫН ДАРХЛААЖУУЛАЛТЫГ ЭРЧИМЖҮҮЛЭХ”
ТӨСЛИЙН АЖЛЫН ДААЛГАВАР

Зорилго: Тарилгатай халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, иргэдийн мэдлэг, хандлагыг сайжруулан, сайн дурын дархлаажуулалтын хамралтыг нэмэгдүүлнэ.

Хугацаа: 2024 он


Санхүүжилтын эх үүсвэр: Орон нутгийн хөгжлийн сан

Гүйцэтгэх ажил:


№	Гүйцэтгэх ажил	Тавигдах шаардлага
1	Байр ашиглалт	Нийгмийн эрүүл мэндийн төвд дархлаажуулалтын өмнө эмчийн үзлэг хийх ,вакцин биобэлдмэл , дагалдах хэрэгслийг хадгалах, сувилагчийн буюу вакцин тарих өрөө, шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангана.
2	Ерөнхий шаардлага	Ажлын өдрүүдэд 08:00-17:00 цагт ажиллана.
		1. Дархлаажуулалт хариуцсан их эмч, 2. Дархлаажуулалтын мэргэжил эзэмшсэн 1 вакцинатор сувилагч 3. Эрүүл мэндийн боловсрол сурталчилгааны асуудал хариуцсан эмнэлгийн мэргэжилтэн буюу олон нийтийн эрүүл мэндийн ажилтан
		Дархлаажуулалттай холбоотой хууль, тогтоол, тушаал, арга зүйн зөвлөмжийн эмхэтгэл, гарын авлага, вакцин тарих заавар, сургалт, сурталчилгааны материал, сэргийлэх тарилгын карт, вакцин биобэлдмэлийн орлого, зарлагын дэвтэр, хэм хяналтын дэвтэр, дархлаажуулалтын тайлангийн маягтууд байна.
		Вакцин хадгалах зориулалтын хөргөгч, вакцин зөөвөрлөх сав, хэм заагуур, хөлдөлтийг тандагч заагуур, мөсөн элемент байрлуулсан байна.
		Нянгийн эсрэг шингэн саван, гар арчих 1 удаагийн хэрэглээний алчуур, спиртийн агууламж 70-80 хувьтай гар халдваргүйжүүлэх бодисоор хангагдсан байна.
		Эмч сувилагч, эх хүүхдэд зориулсан ширээ, сандлууд, тэргэнцэр бүхий ширээ, тарилгын карт хадгалах шүүгээ, аюулгүй хайрцаг, хөлөөр онгойдог хогны сав, 1 удаагийн улавч хэрэглэнэ..
		Яаралтай тусламжийн эм тарианы бикстэй байна.
Үйл ажиллагааны чиглэл	Дархлаажуулалтад хамруулах иргэнийг заавал эмчийн үзлэгт хамруулж, картанд нь тэмдэглэл хөтөлнө.	
	Хийж буй вакцины талаарх мэдээллийг танилцуулж, дархлаажуулалт хийсний дараа 30 минут эмчийн хяналтад байлгана.	
	Эрүүл ахуй, халдвар хамгаалал, аюулгүй тарилгын стандарт журмыг баримталж ажиллах	
	Хөргөгч , хөлдөөгчний хэм хяналтын бүртгэлийг холбогдох журмын дагуу бүртгэх	
	Вакцины төрөл, сери дугаар, дуусах хугацааг тэмдэглэж хаягжуулна.	

2/2

		Төрийн болон төрийн бус, аж ахуйн нэгж байгууллагуудтай хамтран дархлаажуулалтын талаарх сургалтыг тасралтгүй тогтмол зохион байгуулах
		Сайн дурын дархлаажуулалтанд хамрагдсан иргэдийн тоо 15-20 хувиар нэмэгдүүлсэн байх
		Дархлаажуулалтын чиглэлээр иргэдэд тв нэвтрүүлэг, шторк, гарын авлагыг бэлтгэн түгээх
		Эрүүл мэндийн боловсрол сургалт, сурталчилгаа, нөлөөллийн үйл ажиллагааг зохион байгуулах
3	Гүйцэтгэгчид тавигдах шаардлага	Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ авахад орчин ээлтэй байх
		Хүйтэн хэлхээний аюулгүй ажиллагааг баримталж, эрүүл ахуй, халдвар хамгаалал, аюулгүй тарилгын стандарт журмыг мөрдөж ажиллах
		Хувийн нууцыг хадгалах
		Камержуулалтын хяналтын системтэй байх
		Дархлаажуулалтын дараах урвал хүндрэлийг бүртгэж, мэдээлэх vis.health.gov.mn цахим программ дээр ажиллах чадвартай байх
		Ажил гүйцэтгэх гэрээнд заасан хугацаанд ажлаа бүрэн гүйцэтгэх чадвартай байх
		Ажиллах хүний нөөцөөр хангагдсан байх
		Сайн дурын дархлаажуулалтын кабинетын үйл ажиллагааны хэрэгжилт, үйл явцыг үнэн бодитой, баримттай сар, улиралаар тайлагнах

БОЛОВСРУУЛСАН:
 АЙМГИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН ДАРГА  Ч.ОЮУНАА

ТАНИЛЦСАН:
 АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН НИЙГМИЙН
 БОДЛОГЫН ХЭЛТСИЙН ДАРГА  Э.ЭРДЭНЭБИЛЭГ

ХЯНАСАН:
 АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ХӨГЖЛИЙН
 БОДЛОГО ТӨЛӨВЛӨЛТ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН
 ХЭЛТСИЙН ДАРГА  М.НЯМСҮРЭН